

УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ШҮҮГЧ,
УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР,
САНГИЙН САЙДЫН ХАМТАРСАН ЗАХИРАМЖ, ТУШААЛ

2020 оны 11... дүгээр
сарын 08...-ны өдөр

Дугаар 58; 1/07, 2020

Улаанбаатар хот

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ


Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.4 дэх заалт, 14.6 дугаар зүйлийн 8 дахь хэсэг, Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэг, 18 дугаар зүйлийн 18.1.4 дэх заалт, Прокурорын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсгийн 48.1.13 дахь заалт, Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАН, ТУШААХ нь:

1. “Барьцааны мөнгийг байршуулах, шилжүүлэх, шийдвэрлэх журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Прокурор, шүүхээс яллагдагч, шүүгдэгчид мөнгөн хэлбэрээр барьцаа авах таслан сэргийлэх арга хэмжээ авсан тохиолдолд барьцааны мөнгийг энэ журамд нийцүүлэн шийдвэрлэх бэлтгэлийг хангуулж, хэрэгжүүлж ажиллахыг анхан болон давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч, шүүгч, Тамгын газрын дарга, прокурор, аймаг, нийслэл, тээвэр, дүүргийн прокурорын газрын Тамгын хэлтсийн дарга, Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Уг журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн /Б.Цогт/, Улсын Ерөнхий прокурорын орлогч /М.Чинбат/, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /С.Наранцогт/ нарт даалгасугай.

4. Энэхүү хамтарсан захирамж, тушаалыг баталсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдсүгэй.





БАРЬЦААНЫ МӨНГИЙГ БАЙРШУУЛАХ, ШИЛЖҮҮЛЭХ, ШИЙДВЭРЛЭХ ЖУРАМ

УХА0014

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.1 дүгээр зүйлийн 1.4, 14.6 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт зааснаар прокурор, эсхүл шүүхээс яллагдагч болон шүүгдэгчид мөнгөн хэлбэрээр барьцаа авах таслан сэргийлэх арга хэмжээ авсан тохиолдолд барьцааны мөнгийг төрийн сангийн тусгай дансанд байршуулах, шилжүүлэх, шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Энэхүү журам нь Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Монгол Улсын Шүүхийн тухай, Прокурорын тухай, Төсвийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцсэн байна.

Хоёр. Барьцааны мөнгийг байршуулах

2.1. Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх, аймаг, нийслэл, тээвэр, дүүрэг, сум буюу сум дундын прокурорын газар нь Сангийн яамнаас тогтоосон журмын дагуу нээсэн барьцааны мөнгийг хүү, шимтгэлгүйгээр байршуулах төрийн сангийн тусгай данс /цаашид "тусгай данс" гэх/-тай байна.

2.2. Бүх шатны шүүхийн шүүгч, прокурор нь яллагдагч, шүүгдэгч, эсхүл тэдгээрийн өмнөөс хүн, хуулийн этгээдээр барьцааны мөнгийг энэ журмын 2.1-д заасан тусгай дансанд тушаалгаж, байршуулна.

2.3. Барьцаа авах таслан сэргийлэх арга хэмжээ авсан шүүгч, прокурор нь төрийн сангийн тусгай дансанд тушаасан, барьцааны мөнгөний баримтыг таслан сэргийлэх арга хэмжээ авсан шийдвэрийн хамт тэмдэглэл үйлдэж, хэрэгт хавсаргана.

2.4. Барьцааны мөнгийг бэлнээр хүлээн авах, арилжааны болон өөр бусад зорилгоор ашиглахыг хориглоно.

Гурав. Барьцааны мөнгийг шилжүүлэх

3.1. Прокурор эрүүгийн хэрэгт яллах дүгнэлт үйлдэж, хэргийг харьяалах шүүхэд шилжүүлэхдээ барьцааны мөнгийг тухайн шүүхийн төрийн сангийн тусгай дансанд шилжүүлж, баримтыг хэрэгт хавсаргана.

3.2. Хэрэг хянан шийдвэрлэх шүүхийн харьяаллыг өөрчлөн тогтоосон шийдвэрийг үндэслэн барьцааны мөнгийг харьяалал тогтоосон шүүхийн дансанд шилжүүлж, баримтыг хэрэгт хавсаргана.

3.3. Мөрдөн шалгах ажиллагаа явуулах болон прокурорын хяналтын харьяалал өөрчлөгдсөн тохиолдолд зохих тогтоолыг үндэслэн харьяалал тогтоосон прокурорын газрын дансанд барьцааны мөнгийг шилжүүлж, баримтыг хэрэгт хавсаргуулахаар хүргүүлнэ.

3.4. Шүүхээс эрүүгийн хэргийг прокурорт буцаасан тохиолдолд барьцааны мөнгийг тухайн прокурорын газрын тусгай дансанд шилжүүлж, баримтыг хэрэгт хавсаргана.

Дөрөв. Барьцааны мөнгийг шийдвэрлэх

4.1. Яллагдагч, шүүгдэгч нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.6 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 14.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан үүргийг зөрчсөн бол барьцааны мөнгийг үл маргах журмаар улсын орлого болгоно.

4.2. Энэхүү журмын 4.1-д заасан барьцааны мөнгийг төрийн сангийн тусгай данс /100900000707 тоот/-д шилжүүлэхийг шүүхийн шийдвэрт тусгана.

4.3. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.8 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 32.5 дугаар зүйлд заасан тохиолдолд барьцааны мөнгийг барьцаа гаргагчийн дансанд шилжүүлж, баримтыг хэрэгт хавсаргана.

4.4. Шүүхийн шийдвэрийг үндэслэн тухайн шүүхийн тамгын газрын дарга, прокурорын шийдвэрийг үндэслэн тухайн прокурорын газрын тамгын хэлтсийн дарга, сум буюу сум дундын прокурорын газрын ерөнхий прокурор, нягтлан бодогч нар тусгай дансанд байршуулсан барьцааны мөнгөний гүйлгээг хийнэ.

4.5. Энэ журмын 4.4-т заасан албан тушаалтан нь гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулсан төлбөрийн даалгаврыг хэрэгт хавсаргуулахаар шийдвэр гаргасан шүүгч, прокурорт хүлээлгэн өгнө.

4.6. Шүүгч, прокурор нь гүйлгээ хийсэн баримтыг хэрэгт хавсаргана.

Тав. Бусад

5.1. Барьцааны мөнгийг байршуулах, шилжүүлэх, шийдвэрлэх ажиллагаанд шүүгч, прокурор хяналт тавих бөгөөд тэдгээрийн шийдвэрт зааснаас бусад байдлаар барьцааны мөнгийг захиран зарцуулахыг хориглоно.

5.2. Энэхүү журмын 4.4-т заасан албан тушаалтан нь барьцааны мөнгөний тусгай данснаас гүйлгээ хийсэн тохиолдол бүрийг тухайн шүүхийн ерөнхий шүүгч, нэгжийн ерөнхий прокурорт танилцуулна.

5.3. Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх болон аймаг, нийслэл, тээвэр, дүүргийн прокурорын газрын тамгын газар, хэлтсийн дарга, сум буюу сум дундын прокурорын газрын ерөнхий прокурор, нягтлан бодогч нар барьцааны мөнгө байршуулсан тусгай дансны орлого, зарлагын гүйлгээ хийсэн шийдвэрийн талаарх бүртгэлийг хөтөлж, сар, улирал, жилийн мэдээ, тайланг төрийн санд хүргүүлнэ.

5.4. Төрийн сан нь барьцааны мөнгө байршуулсан тусгай дансны орлого, зарлагын гүйлгээнд "Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын дагуу хяналт тавьж ажиллана.

5.5. Энэ журмыг зөрчсөн тохиолдолд хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэх үндэслэл болно.